



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА  
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2016



# АГУУЛГА

## **ГИШҮҮНЧЛЭЛ**

Үндэсний танхимын гишүүнчлэл  
Салбар танхимын гишүүнчлэл  
Шилдэг аж ахуй нэгжээр аялах аян  
Шинэ гишүүдийн үйл ажиллагаатай танилцах аян

## **БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ**

Мэдэгдэл, уриалга  
Санал өгсөн хууль, бодлогын бичиг баримт  
Бодлогын бичиг баримт, хуулийн төслүүдийг боловсруулахад  
ажлын хэсэгт орж ажилласан байдал  
Бусад холбогдох ажлын хэсэг  
МҮХАҮТ-аас төлөөлөн оролцдог хороо, зөвлөл,  
ажлын хэсгийн жагсаалт  
Хэлэлцүүлэг, уулзалт  
“Business breakfast” уулзалт

## **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

Дотоод хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээрүүд  
Хамтын ажиллагааны санамж байгуулахаар  
ажиллаж буй байгууллага  
Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээрүүд

## **ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ**

Монгол-Унгарын бизнес форум  
ТОП-100 аж ахуй нэгж шалгаруулалт  
“Алтанбулаг экспо-2016” арга хэмжээ  
Ази Европын дээд хэмжээний уулзалт  
Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай МҮХАҮТ-ын  
тэргүүлэгчид, удирдах зөвлөлийн гишүүдтэй хийсэн уулзалт  
“B2B meeting”  
Бусад зохион байгуулсан арга хэмжээ, уулзалтууд  
Бизнес уулзалтууд

## **СУДАЛГАА**

### **ҮЗЭСГЭЛЭН**

Дотоод  
Гадаад

## **СУРГАЛТ**

### **ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР**

МҮХАҮТ, ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл  
Азийн сан, Койка ОУБ, НЗДТГ-тай хамтарсан  
бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төсөл  
“Entrepreneurship challenges” орон нутагт  
гарааны бизнесийг дэмжих төсөл

### **ТАНХИМЫН ДОТООДОО ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ**

- Олон улсын худалдааны төвөөс МҮХАҮТ-ын үйл ажиллагаанд  
хийсэн үнэлгээ  
- Нидерландын ахмад экспертүүдийн холбооны зөвлөх Фред дэ Боер  
“Дотоод нөөц бололцоогоо ашиглах нь” төсөл  
- Чанарын удирдлагын ISO9001 стандартын тогтолцоо  
- Танхимын Брэнд бүүк



## МЭНДЧИЛГЭЭ

**М**онгол Улсын хувийн хэвшлийн томоохон төлөөлөл болсон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Удирдах зөвлөлийн гишүүд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, гадаад, дотоод хөрөнгө оруулагч, харилцагч Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье.

Өнгөрсөн ондуудад эдийн засгийн өсөлт саарч, гадаад, дотоод худалдааны салбарт бууралт үргэлжилж, магадгүй ирэх жилүүдэд ч мөн адил манай улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт хумигдах, цаашлаад хямралтай эдийн засаг үргэлжлэх төлөлтэй энэ үед дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч Та бүхэн үргэлж шинэ санал, санаачлагыг гаргаж, үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулж, импортыг орлох олон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, экспортлож, иргэд олон нийтийн эрэлт, хэрэгцээг хангахын сацуу олон хүнийг ажлын байраар хангаж, цалин хөлс, татвар, шимтгэлийг төлж аж ахуйн нэгжийн үүргээ биелүүлэн эдийн засагт өөрсдийн хувь нэмрийг оруулж байгаад талархалтай байна.

Эдийн засгийн хүндхэн байдалд гадаад зах зээлийн орчин нөлөөлж байгаа боловч, нөгөө талаас бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын үр дүнг буруу тооцсон шийдвэр нь эдийн засаг, бизнесийн хөгжилд таагүй нөлөөлж, бизнес эрхлэгч нарт үйл ажиллагаагаа эрхлэх, хэвийн үргэлжүүлэхэд нь саад болж байна.

Өнгөрсөн жил манай улсын иргэд бодлого боловсруулах төрийн түшээдээ сонгож, шинээр байгуулагдсан Засгийн газар нь ирэх 4 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засгийг сэргээх хөтөлбөр зэргийг боловсруулан ажиллаж байна.



Ирэх жилүүдэд эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулахад юун түрүүнд макро эдийн засгийн загварыг шинэчлэх, цаашлаад эдийн засгийг төрөлжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, өрсөлдөх чадварыг дэмжиж, экспортод гаргах, өндөр үр өгөөжтэй хөгжлийн төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь 2016 оныг Засаглалыг дэмжих жил болгон зарлаж, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх зорилгоор холбогдох хууль эрх зүйн бодлогын баримт бичиг дээр ажиллан, төрийн болон төрийн бус байгууллагын 60 гаруй удирдах болон хяналтын зөвлөлд орж бизнесийн эрхлэгчдийн дуу хоолой болж, бизнесийн холбогдох судалгааг хийн бодлого боловсруулагч нарт хүргүүлэн ажилласан.

Цаашлаад үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор дотоод болон гадаадын байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж мөн бизнесийн зах зээлийг өргөжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулахаар бизнес уулзалт, хэлэлцүүлэг, үзэсгэлэн, форум зэргийг зохион байгуулж 2016 оныг амжилтаар үдэж байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь бизнес эрхлэгч Та бүхэнд бизнес эрхлэх таатай орчныг бий болгох, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд Засгийн газар болон холбогдох байгууллагад гишүүн байгууллагуудын санал, зөвлөмж, шүүмжлэлийг хүргэх дуу хоолой нь болж, гишүүд, бизнес эрхлэгчид, харилцагчид, дэмжигчиддээ үзүүлдэг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашлаад төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг илүү сайжруулж хамтран ажиллах болно.

Танхимын 3000 гаруй гишүүн бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, харилцагч, дэмжигчид Та бүхэнд ирж буй Алтан унжлагат Гал тахиа жилийн мэндийг дахин хүргэхийн ялдамд ирэх жилд олз омог, ашиг орлого, буян дэлгэрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАЖАВ



## ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

## АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

## ҮНЭТ ЗҮЙЛС

- **Чадварлаг, эвсэг хамт олон**  
Мэдлэг, боловсрол, үр чадвартай, харилцан бие биенээ хүндэтгэж, сэтгэл гарган, зөв хандлагаар, санаачлагатай ажиллах хамт олон
- **Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа**  
Үр дүнд суурилсан ойлголцол ба итгэлцэлийг эрхэмлэж тогтвортой, үр дүнтэй, оролцоотой хамтын ажиллагааг хөгжүүлэх
- **Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ**  
Эрэлт, хэрэгцээг урьдчилан харж, судлан, төлөвлөж, үйлчлүүлэгч харилцагчдад чанартай, сэтгэл, ханамжтай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох
- **Ёс зүйт үйл ажиллагаа**  
Хурдан, шуурхай, уян хатан, санаачлага гарган үнэнч шударгаар ил тод оролцогч талуудтай үр дүнтэй, хариуцлагатай ажиллах
- **Манлайлал**  
Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн томоохон төлөөлөгч болж санаачлагатай, оролцоотой, тогтвортой хөгжлийн хурдасгагч хүч болон хүртээмжтэй ажиллах




## СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

- Стратегийн зорилт **1** Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилт **2** Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилт **3** Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилт **4** Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилт **5** Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилт **6** Танхимын засаглал, менежментийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх



## ГИШҮҮНЧЛЭЛ

2016 онд үндэсний танхимд шинээр 155 бизнес эрхлэгчид танхимын гишүүнээр элссэн бөгөөд нийт гишүүдийн тоо **3279** болсон. Үүнээс орон нутгийн салбар танхимын гишүүн байгууллага **2206**, үндэсний танхимын гишүүн байгууллага **1073** байна.




### Үндэсний танхимын гишүүн байгууллага

№		Diamond	Platinum	Gold	Classic	Сурвалжлагч	Нийт
1	2016.01.01 гишүүдийн тоо	147	55	116	662	19	<b>999</b>
2	Нэмэгдсэн	17	5	14	129	2	167
3	Хасагдсан	13	7	15	58	0	93
4	2016.12.31 гишүүдийн тоо	151	53	115	733	21	<b>1073</b>



### Үндэсний танхимын гишүүнчлэл




### Салбар танхимын гишүүнчлэл

№	Салбар Танхим	2015 гишүүн	2016 гишүүн	Ажилчдын тоо
1.	Архангай	56	60	3
2.	Баян-Өлгий	39	42	2
3.	Баянхонгор	42	58	2
4.	Булган	45	60	2
5.	Говь-Алтай	53	68	2
6.	Говьсүмбэр	57	54	2
7.	Дархан-Уул	272	277	4
8.	Дорнод	145	161	2
9.	Дорноговь	0	0	1
10.	Дундговь	50	111	2
11.	Завхан	45	56	3
12.	Орхон	166	179	3
13.	Өвөрхангай	142	151	4
14.	Өмнөговь	120	111	3
15.	Сүхбаатар	52	64	3
16.	Сэлэнгэ	46	60	2
17.	Төв	130	126	2
18.	Увс	140	144	2
19.	Ховд	161	52	2
20.	Хөвсгөл	277	285	3
21.	Хэнтий	72	87	2
	<b>Нийт</b>	<b>2110</b>	<b>2206</b>	<b>51</b>



Салбар танхимын гишүүдийн тоо



### Шилдэг аж ахуйн нэгжээр аялах аян

Танхимын гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, гишүүд хоорондын уялдаа холбоог сайжруулах, туршлага хуваалцах зорилгоор 2015 оны онцлох аж ахуйн нэгжээр шалгарсан **15** компаниудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аяныг зохион байгуулж давхардсан тоогоор **421** хүн хамруулсан.

№	Оны онцлох аж ахуйн нэгжтэй танилцах аялал	Хамрагдсан хүний тоо
1.	ООААН-ийн аян - Байгальд ээлтэй ногоон технологи нэвтрүүлэгч Ультрасоник ХХК	60
2.	ООААН-ийн аян - Тээвэр логикийн салбарын 2015 оны онцлох ААН, Entrepreneur УБТЗ-ын ОУТЗТөв	30
3.	Хөдөө орон нутаг руу чиглэсэн ООААН-ийн аян 2 дахь удаагаа зохион байгуулав. <b>Эрдэнэт Үйлдвэр ХХК, Шарын гол ХХК, Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр, Дарханы Дулааны Цахилгаан Станц, Дархан Минж ХХК</b>	25
4.	ООААН-ийн аян "Ай Ти Зон" ХХК	30
5.	ООААН-ийн аян "Шунхлай" ХХК	45
6.	ООААН-ийн аян "Монос групп"	35
7.	Үндэсний үйлдвэрлэгч - Оны онцлох Энтрепренер "Талх чихэр" ХК	36
8.	Аялал жуулчлалын салбарын - Оны онцлох Энтрепренер "Женко Тур Бюро" ХХК	45



9.	Даатгалын салбарын - Оны онцлох Энтрепренер "Тэнгэр даатгал" ХХК	30
10.	Үндэсний үйлдвэрлэгч - Оны онцлох Энтрепренер "Гофро Мануфакторинг" ХХК	35
11.	ЖДҮ – Энтрепренер "Натурал Эссеншлс" ХХК	20
12.	Хүнсний салбарын - Оны онцлох Энтрепренер "Сүү" ХК	30

### Шинэ гишүүдийн үйл ажиллагаатай танилцах аян


Танхимд гишүүнээр элсээд нэг жил болж буй 40 гаруй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах аянг зохион байгуулж танхимын удирдлагын төлөөлөл болон холбогдох газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн хамтаар тэдгээрийн бизнест тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцон, саналуудыг холбогдох газруудад хүргэн ажилласан.





## БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

Бодлогын өмгөөллийн чиглэлээр 2016 онд 14 хууль, бодлогын бичиг баримт дээр ажиллаж санал өгсөн бөгөөд 12 бодлогын бичиг баримт, хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан, 10 хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 мэдэгдэл гарган, нийт 60 хороо, зөвлөл, комисст гишүүнээр төлөөлөн орж ажлын хэсэгт оролцов.



### Мэдэгдэл, уриалга

1. “Улс орны эдийн засаг тогтвортой байдлыг нэхэж байна” мэдэгдэл
2. Компаний засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөртэй холбоотой мэдэгдэл
3. Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, МҮХАҮТ-ын Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл хамтран “Хүртээмжтэй санхүүжилтын санаачилгыг хэрэгжүүлцгээ” тунхаг бичиг
4. “Бизнес эрхлэгчдэд чиглэсэн оновчтой бодлогыг дэмжинэ” уриалга
5. “Төр хувийн хэвшлийн түншлэл, хэлэлцэлийг хөгжүүлэн шинэ шатанд гарган ажиллахыг УИХ, Засгийн газарт УРИАЛЖ байна” уриалга
6. Татварын хувь хэмжээг нэмэх нь зөв шийдэл биш...
7. Валютын ханшийн өсөлттэй холбогдуулан арилжааны банкуудад гаргасан уриалга



### Санал өгсөн хууль, бодлогын бичиг баримтууд

№	Хууль, журам, хуулийн төсөл, бодлогын бичиг баримт	Төлөв
1.	Органик хүнсний тухай	Батлагдсан /2016.04.07/
2.	Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/	Батлагдсан /2016-02-05/
3.	Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	Батлагдсан /2016-02-05/
4.	Демпингийн тухай	Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
5.	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
6.	Татварын ерөнхий хууль	Төсвийн байнгын хороогоор дэмжигдсэн
7.	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
8.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
9.	Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
10.	Хэмжилзүйн тухай хууль	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
11.	Худалдааны тухай хууль	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
12.	Хөдөлмөрийн тухай хууль	УИХ-аас дэмжлэг авахгүй буцаагдсан.
13.	Монгол улсын үндэсний чанарын бодлого, чанарын хөтөлбөр	Засгийн газрын хуралдаанаар батлагдсан.
14.	Арбитрын тухай хууль /шинэчилсэн найруулга/	УИХ-д өргөн баригдсан



**Бодлогын бичиг баримт, хуулийн төслүүдийг боловсруулахад ажлын хэсэгт орж ажилласан байдал**

№	Ажлын хэсгийн нэр	Хийгдсэн ажил	Одоогийн байгаа төлөв /Хийгдэж дууссан эсэх/
1	Арбитрын хуулийн ажлын хэсэг	7 удаа хуралдсан	УИХ-аар анхны хэлэлцүүлэгт ороход бэлэн болсон
2	Стандартын ажлын хэсэг /евро-5/	2016 оны 02-р сарын 23-ний өдрийн 12 тоот тушаалын адгуу календарчилсан төлөвлөгөө ба төсөв гарч ажил нь эхэлсэн. 02/211 тоот албан бичгийг МТ группт явуулсан.	Ажил үргэлжлэн явагдаж байна.
3	Газрын тосны хэвийн хорогдлын судалгааны ажлын хэсэг	2-р сарын 21-нд төлөвлөгөө төсөв батлагдсан.	Ажил үргэлжлэн явандаж байна.
4	АҮЯамны дэргэдэх Худалдааны хуулийн ажлын хэсэг	Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулан Байнгын хороогоор оруулсан. 5 дугаар сарын 18-ны УИХ-ын ЭЗБайнгын хорооны хурлаар Гадаад худалдааны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт орж 100% дэмжигдсэн.	Тухайн хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг шинээр ХХААХҮЯамны дэргэд байгуулагдсан.
5	ЭЗТХэлэлцээрийн гарал үүслийн журмыг хэрэгжүүлэх ажлын хэсэг	ЭЗТХ-ийн гарал үүслийн гэрчилгээний загвар, журам боловсруулсан.	2016 оны 6 сарын 7-оом эхлэн олгож эхэлсэн.
6	Үндэсний Хөгжлийн Газрын дэргэд Тогтворжуулах гэрчилгээ олгох ажлын хэсэг	Ажлын хэсгийн хуралд оролцон санал өгсөн.	
7	ГХЯамны гааль гаалийн тухай тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг	2017 оны 1 сараас гаалийн 3 өөр төрлийн тариф хэрэглэхэд хамтран ажилласан	Байнгын хороогоор дэмжигдэн батлагдсан.



8	Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс (ЕАЭК) хоорондын хамтын ажиллагааны Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдааны ажлын хэсэг	МҮХАҮТ-ын зүгээс Эдийн засгийн хамтын ажиллагааны таатай нөхцөл бүрдүүлэх, тухайлбал тариф, тарифын бус хориг саадыг арилгах асуудлаар чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, гишүүн улс хоорондын бизнесийн холбоог өргөжүүлэх хүрээнд 2017 онд бизнес - форум, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, бусад харилцан ашигтай хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх саналуудыг боловсруулан хүргэсэн.	
9	Органик хүнсний тухай хуулийг дагаж гарах журмуудын ажлын хэсэг		
	Мал аж ахуй	Журам боловсруулахад санал өгөв	Журмын эхний төсөл боловсруулагдсан хэлцэгдэж байна
	Газар тариалан	Журам боловсруулахад санал өгөв	
Боловсруулах үйлдвэр	Журам боловсруулахад санал өгөв		
10	Стандартын хорооны гишүүн	Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл сунгах, олгох	
11	Эрчим хүчний хэмнэлтийг хууль	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал	
12	Монголын банкны холбооны дэргэдэх "Ногоон зээлийн сан"	Ногоон зээлийн шалгуур үзүүлэлт тогтооход санал	Шалгуурууд гарсан хэлцэгдэж байна





## Бусад холбогдох ажлын хэсэг

МҮХАҮТ-аас 2016 онд нийт 60 хороо, зөвлөл, комисст гишүүнээр төлөөлөн орж ажлын хэсэгт оролцон ажилласнаас 44 хороо, удирдах болон ерөнхий зөвлөл, 13 ажлын хэсэгт орж саналаа илэрхийлэн дуу хоолойгоо хүргэж байна.

- МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг Ази Номхон Далайн Орнуудын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Холбооны Дэд ерөнхийлөгч
- Дэлхийн Танхимуудын Холбооны /WCF/ Ерөнхий зөвлөлд Дэлхийн 125 орны 1200 танхимаас нэр дэвшсэн 48 орны ХАҮТ-уудын удирдлагуудаас сонгогдон 2017-2019 оны WCF-ны Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.



Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын дэргэдэх Монгол улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, банк, санхүүгийн салбарын асуудлаар Засгийн газарт бодлогын зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий эдийн засгийн бодлогын зөвлөлд МҮХАҮТ-ын удирдах зөвлөлийн дарга бөгөөд ерөнхийлөгч Б.Лхагважав томилогдсон.



## МҮХАҮТ-аас төлөөлөн оролцдог хороо, зөвлөл, ажлын хэсгийн жагсаалт

№	Харьцдаг байгууллагууд	Хороо, зөвлөл	Түр ажлын хэсэг
1.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар		АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацитай байгуулах хоёр дахь компакт гэрээ боловсруулж, хэлэлцээ хийх ажлыг удирдлага, чиглэлээр хангах ажлын хэсэг
2.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлийн гишүүн	
3.	Сангийн яам		Татварын хуулийн ажлын хэсэг
4.	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам	Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний Зөвлөлийн гишүүн	
5.	Ажил Олгогч Эздийн Холбоо Төр Хувийн хэвшил	3-н талт хэлэлцээр	
6.	Монголын гимнастикийн холбоо	Ерөнхийлөгч	
7.	Торгоны замын Олон улсын худалдааны танхим	Дэд Ерөнхийлөгч	
8.	Гадаад Харилцааны Яам	Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл	
9.			Монгол улс Евроазийн чөлөөл худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсгийн гишүүн
10.		Гаалийн тарифын зөвлөл	
11.	Үндэсний статистикийн хороо	Үндэсний статистикийн хороо зөвлөлийн гишүүн	
12.	Стандарт Хэмжил Зүйн Газар	Стандарчилалын Үндэсний зөвлөлийн гишүүн	
13.	Авилгалтай Тэмцэх Газар	АТГазрын Олон нийтийн зөвлөлийн гишүүн	
14.	Ази номхон далайн орнуудын танхимуудын холбоо	Дэд ерөнхийлөгч	
15.	SGS Монгол ХХК	Шударга ёсны хорооны гишүүн	
16.	Азийн сан	Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх төсөл	
17.	Дэлхийн танхимуудын холбоо	Ерөнхий зөвлөлийн гишүүн	
18.	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар	УЗ-ийн Гишүүн	
19.	Си Жи Эф ХХК	УЗ-ийн гишүүн	



20.	Компанийн засаглалын үндэсний зөвлөл	УЗ-ийн гишүүн	
21.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Сайдын зөвлөлийн гишүүн	
22.	Санхүүгийн зохицуулах хороо	Үнэт цаасны бодлогын зөвлөлийн гишүүн	
23.	Стандарт Хэмжил Зүйн Газар	Цахилгаан техникийн хорооны гишүүн	
24.	Эрчим Хүчний Яам		Монгол улсыг сурталчлан АСТАНА Экспод оролцох ажлын хэсэг (түр)
25.	Гадаад харилцааны яам		“Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг
26.	Гадаад Харилцааны Яам	Монгол Оросын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан технологийн засгийн газар хоорондын комисс	
27.		Монгол Оросын хил худалдаа бүс нутгийн хамтын ажиллагааны дэд комиссын ажлын хэсгийн гишүүн	
28.		Монгол - Польш худалдаа эдийн засгийн комисс	
29.		Монгол - Латви худалдаа эдийн засгийн комисс	
30.		Монгол - Киргиз худалдаа эдийн засгийн комисс	
31.		Монгол - Казакстан худалдаа эдийн засгийн комисс	
32.		Монгол Чех худалдаа эдийн засгийн комисс	
33.	ШӨХТГ	Хараат бус гишүүн	
34.	Зээлийн Батлан Даалтын Сан	Удирдах зөвлөлийн гишүүн	
35.	Стандарт Хэмжил Зүйн Газар	Чанарын удирдлагын техникийн хорооны гишүүн	
36.		Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн техникийн дэд хорооны гишүүн	
37.	Хөгжлийн банк	ТУЗ-ын Хараат бус гишүүн	
38.	Хөдөө Аж Ахуйн Бирж	ХАА-н биржийн зохицуулах зөвлөлийн гишүүн	
39.	Чингэлтэй дүүрэг	ОУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сайн дурын гишүүн	
40.	Гадаад Харилцааны Яам		Хятад улстай ЧХХэлэлцээр байгуулах ажлын хэсгийн гишүүн
41.	Үндэсний хөгжлийн газар	Монгол улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах тухай орон тооны бус зөвлөл	



42.	Хүнс хөдөө аж ахуйн яам		ЗГ-ын Худалдааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн
43.	Гадаад харилцааны яам	Гаалийн тарифын зөвлөлийн гишүүн	
44.	Гаалийн Ерөнхий Газар		Үндэсний Цахим нэг цонхны системийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн
45.			Гаалийн Ерөнхий газар дээр Гаалийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн гишүүн
46.	Гадаад Харилцааны Яам		Худалдаа эдийн засгийн хил орчмын дэд комиссын ажлын хэсгийн гишүүн
47.	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам		Арбитрын хуулийн ажлын хэсгийн гишүүн
48.	CFCFA	CFCFA-ын удирдах зөвлөлийн гишүүн, санхүүч	
49.	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар	Гадаад худалдааг хөнгөвчлөх ЦНЦ-ыг хэрэгжүүлэх удирдах хорооны гишүүн	
50.		ЦНЦ-ны Удирдах хороог удирдлага, арга зүйгээр хангах ажлын хэсгийн гишүүн, Сургалт, хамтын ажиллагаа хариуцсан ажлын хэсгийг Танхимыг төлөөлөн хариуцан ажиллаж байгаа	
51.	Стандарт Хэмжил Зүйн Газар	Худалдаа, нийтийн хоолны стандартчиллын техникийн дэд хорооны гишүүн	
52.	НҮБ	НҮБ-ын АНДЭЗНК-ын экспертүүдийн группын гишүүн	
53.	Стандарт Хэмжил Зүйн Газар	Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийн гишүүн	
54.		Хэмжилзүйн стандартын техникийн хорооны гишүүн	
55.	Зээлийн Батлан Даалтын Сан	Хяналтын зөвлөлийн дарга	
56.	Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрүүд	Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулах хорооны гишүүн	
57.	УУХҮЯ, АМГТГ, СХЗГ, ГЕГ Төв лаборатори, ИНЕГ Оншилгоо хэмжил зүйн лаборатори, ОБЕГ, ЗХНЛаборатори, Химийн хүрээлэн, ШУТИС, Хувийн хэвшлээс МТ, Шунхлай, Мойл, Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг, Нефть Хийн Үндэсний ассоциаци		Евростандартыг орчуулан батлаж ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, зохицуулагч (Euro 5)



58.	УУХҮЯ, АМГТГ, СХЗГ, ГЕГ Төв лаборатори, ИНЕГ Оншилгоо хэмжил зүйн лаборатори, ОБЕГ, ЗХНЛаборатори, Химийн хүрээлэн, ШУТИС, Хувийн хэвшлээс МТ, Шунхлай, Мойл, Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг, Нефть Хийн Үндэсний ассоциаци		Газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлыг шинэчлэн тогтоох ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
59.	Гадаад харилцааны яам		Монгол улс, БНСУ хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж нөхцлийг судлах судалганы багийн гишүүн
60.	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн	

## Хэлэлцүүлэг, уулзалт

№	Хэлэлцүүлгийн сэдэв	Хугацаа
1.	Дэмпингийн тухай хуулийн хэлэлцүүлэг	2016.5.6
2.	Хөдөлмөрийн тухай хуулийн хэлэлцүүлэг	2016.4.4
3.	Импортын зарим барааны гаалийн татварыг нэмэгдүүлсэнтэй холбоотой компани аж ахуйн нэгжүүдтэй хийсэн хэлэлцүүлэг	2016.3.14
4.	МХЕГ болон МҮХАҮТ-ын ЭДХГ хамтран зохион байгуулсан “Махны экспортын төрийн бодлого” түүний хэрэгжилтийн тухай хэлэлцүүлэг	2016.3.21
5.	Цементийн импортын бизнес эрхлэгчдийн уулзалт хэлэлцүүлэг	2016.2.23
6.	Худалдаа, тээврийг хөнгөвчлөхөд логистикийн гүйцэтгэх үүрэг сэдэвт өдөрлөг, хэлэлцүүлэг	2016.4.20
7.	Барилгын салбарын хууль эрх зүйн орчны хэлэлцүүлэг	2016.3.30
8.	“Төрөөс экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний талаар баримталж буй бодлого” түүний хэрэгжилтийн тухай хэлэлцүүлэг	2016.6.20
9.	Монголын банкнуудын холбоо, барилгын салбарын гарц, боломж хайсан хэлэлцүүлэг уулзалт	2016.4.27
10.	Валютын ханш огцом өссөнтэй холбоотой гурван талын уулзалт-хэлэлцүүлэг	2016.12.15



## “Business breakfast” уулзалт

Бизнес эрхлэгчдийг төртэй холбох, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайржуулах зорилгоор “Business breakfast” өглөөний уулзалтыг энэ онд шинээр санаачлан хэрэгжүүлж нийт 12 удаа зохион байгуулсан. Салбарын асуудал эрхэлсэн сайд нар

болон эдийн засагч нартай уулзаж санал бодлоо солилцох уг уулзалтанд давхардсан тоогоор 1100 орчим бизнес эрхлэгчдийн дунд амжилттай зохион байгуулж салбарын сайдтай асуудлаа хэлэлцсэн.



№	Оролцсон зочин	Хэзээ	Оролцогсдын тоо	Хүрсэн үр дүн
1.	УИХ-н гишүүн С.Бямбацогт	2016.02.18	51	Танхимын тэргүүлэгч болон удирдах зөвлөлийн гишүүд, 2015 оны шилдэг энтрепренёрууд оролцов.УИХ дахь МАН-ын бодлого үзэл баримтлалыг танилцуулж, бизнес эрхлэгчдийн санал хүсэлтийг уламжилсан, Монгол –Хятадын зөвлөлийн ажлыг улам сайжруулах
2.	УИХ-н гишүүн Б.Гарамгайбаатар	2016.03.29	70	УИХ дахь АН-ын бодлого үзэл баримтлалыг танилцуулж, бизнес эрхлэгчдэд мэдээлэл өгсөн, цаашид хамтран ажиллах
3.	УИХ-н гишүүн, БХБ-ын сайд З.Баянсэлэнгэ	2016.04.19	65	Салбарын ААН, байгууллагуудыг дэмжиж хамтарч ажиллах, тулгамдаж буй асуудлуудаар яаман дээр хамтарсан уулзалт зохион байгуулсан
4.	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2016.04.29	60	Хуулиудын өөрчлөлт, шинэчлэлд бизнес эрхлэгч, судлаач, эрдэмтэдийн саналыг тусгах, ажлын хэсэгт оруулах боломжтой.
5.	Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат	2016.05.27	50	Салбарын мэдээллийг гишүүдэд өгч, тулгамдсан асуудлаар уулзах боломж бүрдсэн



6.	ХХАА-н сайд Р.Бурмаа	2016.05.18	70	Уулзалтын үр дүнд Монголын тэргэнцэртэй иргэдийг дэмжих Төмөр санд үр тариа олгов
7.	ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, яамны газрын дарга н.Батхүү болон холбогдох мэргэжилтнүүд,	2016.09.29	100	Цаашид шинэ Засгийн газар, УИХ-ын гишүүд, төрийн байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Нийт 6 удаа зохион байгуулагдсан,
8.	УИХ-ын гишүүн Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч асан Б.Жавхлан	2016.10.24	70	2016.10.26 нд Байнгын хороогоор хэлэлцэх Монгол улсын мөнгөний бодлого, 2017 онд баримтлах чиглэлд бизнесийн салбарын санал, хүсэлт тусгагдсан.
9.	УИХ-ын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайд Н.Номтойбаяр	2016.11.11	150	Хамтын ажиллагааны эхлэл тавигдаж, ХНХЯ-ны сайдын зөвлөл, НД үндэсний зөвлөл, ХТХ-ын шинэчилсэн найруулгын ажлын хэсэгт орж ажиллах зэрэг боломжууд нээгдсэн. Бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтарч ажиллахаа мэдэгдсэн.
10.	Монгол Улсын Ерөнхий сайд асан, эдийн засагч Р.Амаржаргал	2016.11.25	110	Монголын эдийн засгийн өнөөгийн байдлын талаар гишүүдэд мэдээлэл өгч, асуултад хариулт өгсөн. Танхимын эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөхөөр ажиллахаар болж, ажлаа Зүүн 3 аймгийн бизнесийнхэнд сургалт, уулзалт хийж эхлүүлээ.
11.	Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаяр	2016.12.02	80	Салбарын өнөөгийн тулгамдаж буй асуудалд бизнесийн салбарынхантай хамтарч ажиллах, гарц шийдлийг олох, төсөл хөтөлбөр, тендерийн асуудлыг оновчтой шийдвэрлэх цаашид танхимтай хамтарч ажиллахаар боллоо.
12.	Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат	2017.01.13	240	Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлын талаар, цаашид хамтран ажиллах боломжийн талаар мэдээлэл өгсөн. Мөн бизнес эрхлэгчид салбарын өмнө тулгамдаж буй асуудал, бэрхшээлийн талаар саналаа хэлж, бичгээр өгсөн. Танхимын зүгээс бизнес эрхлэгчдийн саналыг боловсруулан бичгээр хүргэж цаашид олон үйл ажиллагааг хамтран зохион байгуулахаар болсон.



## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Төр болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудтай байгуулсан санамж бичгийн хүрээнд үйл ажиллагааг өргөжүүлэн явуулсаар байгаа бөгөөд 2016 оны байдлаар дотоодын **11** байгууллага, гадаадын худалдааг дэмжих **15** байгууллагатай хамтын ажиллагааны санамжт гарын үсэг зурсан бөгөөд 2017 онд гаргаад ЗГХЭГ, УИХ-ын тамгын газар, ХЗДХЯ, МУИС зэрэг байгууллагатай санамж бичиг зурахаар ажиллаж байна.

### Дотоод хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээр

1. Онцгой байдлын ерөнхий газар
2. Монголын хөрөнгийн бирж
3. Улаанбаатар төмөр замын үйлчилгээний төв
4. Буянт-Ухаа трейд ХХК
5. Монголын хуульчдын холбоо
6. Скай хайпермаркет ХХК
7. Монголын Дипломатын академи ТББ
8. Нефть хийн үндэсний ассоциаци хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг
9. ХХААЯ, Номин трейдинг
10. Монгол улсын эрчим хүчний зохицуулах хороо
11. Канадын Юнитерра хөтөлбөр

### Хамтын ажиллагааны санамж байгуулахаар ажиллаж буй байгууллага

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газар
2. Улсын их хурлын тамгын газар
3. Хууль зүй, дотоод хэргийн яам
4. Монгол улсын их сургууль



## Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээр

1. Бразил Улсын Сан Паоло хотын ХАҮТ
2. Унгарын ХАҮТ
3. Унгарын Үндэсний худалдааны төв
4. Татарстаны ХАҮТ
5. БНХАУ-ын Шенян хотын Худалдааг Дэмжих Хороо
6. Юнь Нан хотын худалдааны танхимтай хамтран ажиллах стратегийн гэрээ
7. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдааг Дэмжих Хороотой интернэт сүлжээг ашиглан бүс нутгийн худалдааг дэмжих, мэдээллийг бэхжүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр
8. Монгол, Хятадын маргаан эвлэрүүлэн зуучлах төвийн хамтын ажиллагааны хэлэлцээр
9. Дорнод аймаг дахь салбар танхим, БНХАУ-ын Манжуурын ХДХ, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын ХАҮТ хооронд “noborder.ru” веб сайтын үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл солилцож хамтран ажиллах гэрээ
10. БНСУ-ын Жижиг дунд бизнесийн корпорацитай хамтын ажиллагааны санамж бичиг
11. БНСУ-ын Олон улсын эдийн засгийн бодлогын институттай хамтын ажиллагааны санамж бичиг
12. БНСУ-ын Аж үйлдвэрийн цогцолбор корпорацитай хамтын ажиллагааны санамж бичиг
13. БНСУ-ын ХАҮТ-тай хамтын ажиллагааны санамж бичиг
14. Индонезийн ХАҮТ-тай хамтын ажиллагааны санамж бичиг

Хамтын ажиллагааны санамж бичиг



## ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах, зах зээлээ өргөжүүлэн хамтын ажиллагаа, хоорондын уялдаа холбоог сайжруулах, салбарын өмнө тулгамдаж буй асуудал болон ололт амжилтын талаар санал бодлоо солилцох гэх мэт олон зорилгын дор 2016 онд нийт 70 гаруй арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 15717 хүнийг хамруулсан байна.

### Монгол-Унгарын бизнес форум

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн урилгаар Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбан /Victor Orban/ Монгол Улсад 01 дүгээр сарын 25-ны өдөр айлчилсан. Айлчлалын үеэр Монгол-Унгарын бизнес форум, болж хоёр улсын бизнес эрхлэгчдийн дугуй ширээний уулзалт, Унгарын аж ахуйн нэгж, байгууллагуудын үзэсгэлэн худалдаа, ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр Унгарын үндэсний худалдааны байгууллагын захирал хатагтай Ката Пал, Монголын талаас Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, хөгжлийн банкны эрсдлийн удирдлагын газрын захирал П.Батбаяр нар нь хөрөнгө оруулалтын боломжууд сэдвээр тус тус илтгэл тавьж



цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсон. Тус уулзалтанд Унгарын талаас аялал жуулчлал, автомашин, цахим технологи, барилга, архитектур, хүнс, банк, санхүү, хөдөө аж ахуй гэх мэт нийт 40 гаруй аж ахуйн нэгж, монголын 200 гаруй бизнес эрхлэгчид уг уулзалтанд оролцсон.





## ТОП-100 аж ахуйн нэгж шалгаруулалт

Монгол улсын Засгийн Газартай хамтран 2015 оны “ТОП-100” аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлыг 15 дах жилдээ Сангийн яам, Гааль, татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар,

Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газартай хамтран эрэмбэлж Төрийн ордонд шагнал гардуулах ёслолын арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.



## “Алтанбулаг экспо - 2016” арга хэмжээ

2016 оны 5 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд “Алтанбулаг экспо 2016” арга хэмжээг Аж үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яам, МҮХАҮТ-ын Сэлэнгэ аймаг дахь салбар танхимтай хамтран амжилттай зохион байгуулсан.

Алтанбулаг экспо 2016” олон улсын форум, үзэсгэлэнг зохион байгуулснаар 2016.05.21-22-ы өдрүүдэд Алтанбулагийн чөлөөт бүс рүү 2850 тээврийн хэрэгсэл, 9229 зорчигч нэвтэрч, БНХАУ-ын талаас 30 гаруй, ОХУ-ын талаас 20 гаруй, манай талаас 50 орчим бизнес эрхлэгч, мөн тооны хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачид оролцсон.

Аж үйлдвэрийн сайдтай хамтран МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч энэ үеэр Алтанбулаг чөлөөт бүсийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах асуудлын хүрээнд Буриад улсын Ардын их хурлын дарга

дарга Ц.Э. Доржиев болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин нартай уулзалт хийсэн.

“Алтанбулаг экспо 2016” олон улсын



форум, үзэсгэлэнд дотоодын 120 гаруй аж ахуй нэгж оролцож, бараа, бүтээгдэхүүнээ танилцуулсан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр 112.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн болно.





## Ази Европын дээд хэмжээний уулзалт

2016 оны 7 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд хооронд Ази Европын дээд хэмжээний уулзалтын үеэр /ASEM/ Ази европын бизнес форумын “Ази Европын уялдаа холбоо” салбар хуралдааныг зохион байгуулсан. Уг хуралдаанд танхимаас нийт 117 бизнес эрхлэгчид салбар танхимын төлөөллийг хамруулсан.

7 дугаар сарын 14-ний өдөр Ази Европын дээд хэмжээний уулзалтанд оролцсон Камбоджийн Худалдааны Танхим, Торгоны зам Олон улсын худалдааны танхим, Тайландын Худалдааны Танхим болон Тайланд улсын худалдааны зөвлөлийнхнөөс бүрдсэн 15 төлөөлөгчдийг МҮХАҮТ-ын удирдлагууд хүлээн авч уулзсан.



## Монгол Солонгосын бизнес форум

Улаанбаатар хотноо болсон АСЕМ-ын 11 дэх дээд хэмжээний уулзалтад оролцсон БНСУ-ын Ерөнхийлөгч, эрхэмсэг хатагтай Пак Гын Хэгийн манай улсад хийсэн айлчлалын хүрээнд долдугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол-Солонгосын бизнес форумыг МҮХАҮТ, БНСУ-ын Худалдаа, Аж үйлдвэрийн




Танхим (KCCI) хамтран зохион байгуулав. Уг форумд Өмнөд Солонгосын 190 орчим төлөөлөл, манай талаас 270 бизнес эрхлэгч, албаны хүмүүс оролцов.

## Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай МҮХАҮТ-ын тэргүүлэгчид, удирдах зөвлөлийн гишүүдтэй хийсэн уулзалт

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай МҮХАҮТ-ын Удирдах Зөвлөлийн гишүүдийг уулзуулан татварын орчин, бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, даван туулах арга зам, бизнесийн орчныг сайжруулах талаар санал бодлоо солилцов.

МҮХАҮТ баялаг бүтээгч, татвар төлөгчдийн өмнө тулгамдаж байгаа асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх болон мөнгөний бодлого, макро эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах долоон зүйл **55** заалт бүхий саналаа Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад хүлээлгэн өгсөн.





## “B2B meeting”

Бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, цаг үеийн асуудлаар мэдээллийг хуваалцах, санал солилцох чөлөөт индэрийг бий болгох зорилгоор B2B уулзалтуудыг 8 удаа зохион байгуулж тухайн асуудал хариуцсан төрийн байгууллагын төлөөлөл, салбарын эрдэмтэн судлаач, мэргэжлийн экспертүүд болон гадаадын бизнес эрхлэгчид нийт 700 гаруй хүмүүсийг хамруулав.

№	Арга хэмжээний нэр	Хэзээ	Оролцогсдын тоо
1.	“Хөдөлмөрийн харилцаан дахь эрх зүйн орчин”	2016.02.26	73
2.	Тогтвортой хөгжил ба тогтвортой санхүүжилт	2016.03.29	100
3.	Corporate & start-up	2016.04.29	100 орчим старт ап 20 томоохон аж ахуй нэгж
4.	Нягтлан бодох бүртгэл болон аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, өөрчлөлт болон тоон гарын үсгийн хэрэглээ, хэрэгжүүлэлт	2016.06.13	140
5.	“Гаалийн зуучлагч байгууллагын өнөөгийн байдал анхаарах асуудлууд”	2016.09.30	70
6.	Макро эдийн засгийн төлөв байдал: Боломж уу? уулзалт	2016.10.28	95
7.	Худалдааны хууль, хөдөлмөрийн хууль, Арбитрын хуулийн танилцуулга	2016.11.30	42
8.	Монгол-Солонгосын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа	2016.11.1	60



## Бусад зохион байгуулсан арга хэмжээ, уулзалтууд

№	Арга хэмжээний нэр	Хэзээ	Оролцогсдын тоо
1.	“Торгоны зам 2016” шагнал гардуулах арга хэмжээ	1-р сар	80
2.	“Усны үнэ цэнэ” форум	2-р сар	80
3.	Нефть хийн үндэсний ассоциаци төрийн бус байгууллагатай евро стандартыг батлуулах ажлын хэсгийн уулзалт	3-р сар	14
4.	Гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг дэмжих ажлын хүрээнд Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр хэрэгжүүлэх Юнитерра хөтөлбөртэй хамтран Монгол улсын ноос ноолуурын салбарын бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт	3-р сар	40
5.	МУ-ын ТОП-100 аж ахуйн нэгж шалгаруулах арга хэмжээ	4-р сар	120
6.	Силк Роуд 2015 арга хэмжээ	4-р сар	12
7.	Газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлын судалгааны багийн хурал	4-р сар	8
8.	АНУ-ын махны холбооны дэд ерөнхийлөгч болон Монголын махны компаниудын уулзалт	4-р сар	70
9.	“Идэхийн тулд амьдрах уу?, Амьдрахын тулд идэх үү?” хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, эрдэмтэдийн чуулга уулзалт	5-р сар	92
10.	Emart “Export to Korea”	5-р сар	50
11.	НҮБ-ын Хүнс ХАА-н байгууллагаас хэрэгжүүлж буй Монголын махны экспортыг нэмэгдүүлэх тухай төсөл, ХХААЯамтай хамтран Махны экспортын форум	5-р сар	70
12.	“Ногоон технологи инноваци” зөвлөгөөн	5-р сар	120
13.	ОБЕГ-тай хамтран гамшгийн эрсдэлийг бууруулахад төр-хувийн хэвшлийн түншлэл форум		90
14.	СЗХ-оос зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн чадавхийг бэхжүүлэх хэлэлцүүлэг, уулзалт		140
15.	“Тээвэр хөнгөвчлөх арга хэрэгслүүд” үндэсний семинар	6-р сар	100
16.	Нефть хийн үндэсний ассоциаци, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч нарын хамтарсан хурал	6-р сар	24
17.	“Тогтвортой аялал жуулчлал” семинар	6-р сар	14
18.	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форум	6-р сар	500
19.	Худалдаа, тээврийн салбарын хамтарсан уулзалт		42
20.	Логистикийн өдөрлөгийн хүрээнд хийсэн хэлэлцүүлэг		120
21.	МУЗН-ийн ази, номхон далайн бүсийн худалдан авах ажиллагааны талаар уулзалт	9-р сар	23





22.	Бүс нутгийн баталгааны системийн талаарх уулзалт	10-р сар	12
23.	Оролцооны баталгаажуулалтын олон улсын сургалт, семинар	10-сар	250
24.	Оюу-толгой ХХК-ийн ханган нийлүүлэгчдийн уулзалт	11-р сар	120
25.	Их Британийн "Great" төсөл танилцуулах арга хэмжээ	11-р сар	47
26.	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт сэдэвт уулзалт	11-р сар	26
27.	Үндэсний чанарын форум	11-р сар	250
28.	Бага нүүрстөрөгч бүхий төслүүдийг дэмжих Хамтарсан Кредит Олгох Механизм уулзалт	12-р сар	60

## Бизнес уулзалтууд

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг байгуулж, давхардсан тоогоор 1950 дэмжих, зах зээлийг өргөжүүлэх, хамтын хүнийг хамруулсан. Гадаадын 4 оронд 5 ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Монгол удаагийн арга хэмжээ зохион байгуулж, улсад 15 бизнес уулзалтуудыг зохион 155 хүнийг оролцуулав.

Үүнд:

№	Арга хэмжээний нэр	Хэзээ	Оролцогсдын тоо
<b>Монгол улсад зохион байгуулагдсан:</b>			
1.	Монгол-Унгарын бизнес форум	1-р сар	245
2.	Монгол Японы бизнесийн харилцааг идэвхижүүлэх нь сэдэвт семинар	1-р сар	60
3.	Олон улсын "Ворота в Азию 2016" 26 дахь удаагийн үзэсгэлэн, бизнес форум	4-р сар	40
4.	15 дахь удаагийн ээлжит "Монгол-Тайваний Худалдаа, эдийн засгийн хамтарсан уулзалт"	5-р сар	80
5.	Эрээн хотын Хилийн чөлөөт бүсийн танилцуулга уулзалт хурал	5-р сар	400
6.	Монгол-Татарстаны бизнес форум	6-р сар	65
7.	Монгол-Австрийн бизнес форум	6-р сар	48
8.	АСЕМ-ийн Чуулганы Ази, Европын Бизнес Форумын "Ази, Европын уялдаа холбоо" сэдэвт салбар хуралдаан	7-р сар	400
9.	Монгол-Солонгосын бизнес форум	7-р сар	270
10.	БНХАУ-ын Нинся мужийн худалдааны танхимын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн МУ-д хийсэн айлчлал	7-р сар	80
11.	Монгол-Чехийн бизнес эрхлэгчдийн уулзалт	9-р сар	62
12.	Монгол-Бразилын анхдугаар танилцах бизнес уулзалт	9-р сар	37



13.	Монгол-Оросын бизнес уулзалт	9-р сар	45
14.	Монгол-Казахстаны бизнес уулзалт	10-р сар	99
15.	БНХАУ-ын Шанси мужийн Жанжье хотын төлөөлөгчдийн Монголын бизнес эрхлэгчидтэй хийсэн уулзалт	11-р сар	32
<b>Олон улсад зохион байгуулагдсан:</b>			
1.	Малайз улсын Куала Лампур хотноо болсон 13 дахь удаагийн халал бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэн, бизнес уулзалт	3-р сар	30
2.	БНСУ-д Монголын бизнес эрхлэгчдийн айлчлал	4-р сар	14
3.	Хятад, Монгол, Оросын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны 8 дахь удаагийн Чуулга уулзалт	9-р сар	60
4.	МУ-ын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд бизнес эрхлэгчдийн айлчлал	10-р сар	40
5.	БНСУ-д хийсэн Монголын бизнес эрхлэгчдийн айлчлал, Солонгос-Монголын бизнес семинар	11-р сар	9





## СУДАЛГАА

Судалгааны агуулга	Судалгааны зорилго	Үр дүн
Бизнесийн орчны судалгаа	Монголын бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээнүүд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоог тодорхойлоход чиглэгдсэн. Энэхүү судалгааг МУИС-ийн Бизнесийн сургууль, МҮХАҮТ-тай хамтран боловсруулсан.	Улаанбаатар хотын 526 аж ахуй нэгж, орон нутагт 1301 нийт 1828 аж ахуй нэгжийг хамруулсан судалгаа авсан бөгөөд одоо судалгааг нэгтгэн, боловсруулах шатандаа явж байна.
Бизнесийн итгэлийн индекс	Бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, түүний өөрчлөлтийн талаарх хүлээлт, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаар бизнес эрхлэгчид, иргэдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчинд таатай, таагүй нөлөө үзүүлж буй төрийн бодлого шийдвэр, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлууд зэрэг эдийн засаг бизнесийн орчны чухал үзүүлэлтүүдээр судалгаанд оролцогчдын саналыг тоймлон гаргах	Бизнесийн итгэлийн индексийн судалгаанд нийт 826 хүнийг хамруулж судалгааг боловсруулан хэвлэн гаргасан.
Гадаад дотоод зах зээлийн тойм, чиг хандлага	Гадаад худалдаа эрхлэгч бизнесийн байгууллагуудад болон шинээр бизнес эхлүүлэх гэж буй бизнес эрхлэгчдэд зориулж зах зээлээ судлах, үнэ ханшаа тогтоох, эрсдлээ тооцоолох зэрэгт дэмжлэг үзүүлэх	2016 онд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний гадаад болон дотоод зах зээлийн тойм судалгаа 11 бүтээгдэхүүн дээр хийсэн. Мөн 4 бүтээгдэхүүний 2017 оны үнийн болон үйлдвэрлэлийн чиг хандлагын судалгаа хийсэн.
Байгууллагын захиалгат судалгаа	Байгууллагуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн зах зээлийн сигментчилсэн судалгаа хийх	Төмөр, улаан буудай, гурил, чацаргана зэрэг бүтээгдэхүүний зах зээлийн тойм судалгааг бэлтгэн гаргасан.



## ҮЗЭСГЭЛЭН

### Дотоод

Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээг- дангаараа, төрийн болон төрийн бус дэхүүнийг таниулан сурталчлах, байгууллагуудтай хамтран зохион борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийг байгуулсан. 9 үзэсгэлэнд 434 аж ахуй өргөжүүлэх зорилгоор 20 гаруй үзэсгэлэнг нэгж оролцсон байна.

№	Үзэсгэлэнгийн нэр	Хэзээ
1.	“Монголд үйлдвэрлэв-2016” Цагаан сарын үзэсгэлэн	2016.01.27-02.07
2.	Look Mongolia ХХК хамтран “Монголиа Майнинг 2016” Олон улсын уул уурхай газрын тосны үзэсгэлэн	2016.04.06-08
3.	“Ворота в Азию” 26 дах удаагийн ОХУ-ын бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн	2016.04.19-21
4.	Coal and Metals Mongolia 2016 үзэсгэлэн	2016.05.06-07
5.	“Ногоон технологи-инноваци-2016” үзэсгэлэн	2016.05.10-11
6.	“Алтанбулаг Экспо -2016”	2016.05.18-23
7.	MICS - 2016 Олон улсын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн	2016.06.09-13
8.	Бугатын өдрүүд ӨМӨЗО-ны бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа	2016.08.05-07
9.	ӨМӨЗО-ны ССРIT-аас Хөх хотын ААН-н үзэсгэлэн	2016.08.12
10.	Хятадын СМЕК байгууллагаас зохион байгуулсан Гэр ахуйн материал үзэсгэлэн	2016.08.26-28
11.	Улаанбаатар түншлэл 2016 Олон улсын намрын үзэсгэлэн	2016.09.08-11



## Гадаад

Монголын экспортын барааг гадаад зохион байгуулж 300 гаруй аж ахуйн зах зээлд гаргахад дэмжих, сурталчлах нэгж оролцож бүтээгдэхүүнээ сурталчлан зорилгоор БНСУ, БНХАУ, ОХУ, ХБНГУ борлуулав. ээрэг орнууд руу 7 удаагийн үзэсгэлэн

№	Үзэсгэлэнгийн нэр	Хэзээ
1	Harbin Asian Cold Zone EXPO 2016 ОУ-ын үзэсгэлэн	2016.01.05-12
2	БНСУ-ын Илсан хотын Кинтекс ОУ-ын үзэсгэлэнгийн төвд “Cosmetic inside korea” үзэсгэлэн	2016.04.26-29
3	“Ий-Үү хотын Шилдэг Импорт Экспортын Барааны Үзэсгэлэн”	2016.05.09-19
4	2016 Тунляо Үндэстэн Ястны Бараа Бүтээгдэхүүний Үзэсгэлэн Худалдаа	2016.08.12-14
5	БНХАУ-ын Эрээн хотноо “ОХУ, Монгол, БНХАУ-ын 3 талт чуулга уулзалт, үзэсгэлэн”	2016.09.03-07
6	БНХАУ-ын Шиньжиан Уйгарын Өөртөө Засах Оронд зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн	2016.09.20-25
7	ХБНГУ-д Берлин базаар олон улсын үзэсгэлэн	2016.11.16-20



## СУРГАЛТ

Танхимын дэргэд Гадаад худалдааны академид 7 төрлийн сургалтаар нийт 700 орчим хүнийг хамруулсан. 2016 онд Гадаад худалдааны академийн сургалтын хөтөлбөр, хичээл зааж буй багш нарыг шинэчлэн сайжруулсан.

№	Сургалтын нэр / агуулга	Хамрагдсан хүний тоо
1.	Гадаад худалдааны менежер бэлтгэх сургалт 2015-2016 оны хичээлийн жил	Анги: 3 Оюутан: 55 Хугацаа: 1 жил
2.	Гадаад худалдааны менежер бэлтгэх сургалт- 2016-2017 оны хичээлийн жил (Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн)	Анги: 2 Оюутан: 64 Хугацаа: 1 жил
3.	Даргын туслах бэлтгэх сургалт (Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн)	Анги: 3 Оюутан: 41 Хугацаа: 9 сар
4.	Сүлжээний мэргэжилтэн бэлтгэх сургалт	Анги: 2 Оюутан: 11 Хугацаа: 10 хоног
5.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх сургалт (Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн)	Анги: 7 Оюутан: 192 Хугацаа: 1 жил (21, 45 хоногоор 7 удаа)
6.	Талх, нарийн боовны сургалт	Ганцаарчилсан: 23 хүнд Бүлэг: 9 хүнд
7.	Богино хугацааны сургалт (Сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн)	Хэмжих нэгж: 12 удаа Хүн: 295 Хугацаа: 4 цагаас 2 өдөр




Бизнес эрхлэгчдэд зориулан гадны экспертүүд болон мэргэжилтнүүдээр сэдэвчилсэн сургалтуудыг 16 удаа зохион байгуулж нийт 3000 орчим хүн хамрагдаж мэдээлэл авсан. Ялангуяа НӨАТ-ын хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор ГТЕГ болон дүүргүүдтэй хамтран холбогдох мэдээллийг бизнес эрхлэгчидэд хүргэсэн.

№	Сургалтын нэр / агуулга	Хамрагдсан хүний тоо
1.	Хөдөлмөрийн яамны Эрүүл мэндийн төвтэй хамтран ХАБЭА, ажлын байрны эрүүл ахуйн талаар худалдаа эрхлэгчдэд зориулсан сургалт	50
2.	Blue economy лекц	80
3.	Хямралын үеийн менежмент сургалт	28
4.	Бизнесийн сургуулийн оюутнуудад танилцуулах сургалт	39
5.	Гоёл кашмер ХХК дээр сургалт	23
6.	Тээвэр, логистикийн салбарын хууль эрх зүйн сургалт	29
7.	Тээвэр зуучийн анхан шатны сургалт	46
8.	Жижиглэн худалдаа эрхлэгчдэд зориулсан сургалт	13
9.	"Тендерийн санал боловсруулах сургалт"	4
10.	ГТЕГ, дүүргүүдийн ТХ-тэй хамтарсан сургалт 1/27,30 2/3,4,7 10, 27нд 14 удаа /НӨАТ, Е- баримт, НӨАТ талон, программ ашиглах./	2000 гаруй
11.	"Олон нийттэй харилцах ажилтны сургалт"	18
12.	Газрын тосны салбарын ажилтнуудад зориулсан түргэвчилсэн сургалт	46
13.	"Тогтвортой аялал жуулчлал" семинар сургалт	14
14.	Бага нүүрстөрөгч бүхий төслүүдийг дэмжих Хамтарсан Кредит Олгох Механизм сургалт	60
15.	Оролцооны баталгаажуулалтын олон улсын сургалт	250




## ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Гарал үүслийн гэрчилгээний тоо



Үйлчилгээний тоо





### Үйлчилгээний тоо



### Үйлчилгээний тоо



Арбитрын шүүх дээр үүссэн маргааныг гэрээний төрлөөр авч үзвэл:

2016 онд нийт 100 нэхэмжлэл шинээр хүлээж авснаас 46 хэргийг шийдвэрлэсэн байна. Мөн өмнө оны гуч гаруй хэрэгт арбитрын ажиллагаа явагдсанаас 28 хэргийг эцэслэн шийдвэрлэж нийт 74 хэрэгт арбитрын шийдвэр гарсан байна.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2-т зааснаар арбитрын ажиллагаа явуулах хугацаа 60 хоног байх хэдий ч хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал, талуудын оролцоо, арбитрын ажиллагаанаас шалтгаалан түүнээс удаан хугацаанд шийдвэрлэгдэх нь бий. МОУҮА-аар шийдвэрлэгдсэн 74 хэргийн шийдвэрлэгдсэн хэргүүдийн хувьд 1 хэрэг дунджаар 159 хоногт буюу 5 сарын хугацаанд шийдвэрлэгдсэн байна.

Мөн дээрх 74 хэргээс 10 хэрэгт талууд эвлэрэн хэлэлцсэний үндсэн дээр арбитраас эвлэрлийн гэрээг баталгаажуулж арбитрын ажиллагааг дуусгавар болгосон бол, 7 хэргийн нэхэмжлэгч нэхэмжлэлээ татан авах эсвэл татгалзах хүсэлт гаргасны үндсэн дээр арбитрын ажиллагааг дуусгавар болгосон байна. Мөн 2 хэргийн арбитрын ажиллагааг түдгэлзүүлсэн шийдвэр гарсан байна.

### Маргаан үүссэн гэрээний төрлөөр





## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

### МҮХАҮТ, ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл

МҮХАҮТ, ГХАҮТХ хамтран ХБНГУ-ын Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Яамнаас санхүүжилттэй Монголын бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр Архангай аймагт хонины ноос, Увс аймагт чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл 2015.09-2018.08 сарын хооронд 3 жилийн хугацаатай хэрэгжиж байна.

#### Төслийн хүрээнд:

- Увс аймгийн ХАҮТ-ын дэргэд Чацарганы салбарыг дэмжих 15 хүний бүрэлдэхүүн, Архангай аймгийн ХАҮТ-ын дэргэд ноосны салбарыг дэмжих 11 хүний бүрэлдэхүүнтэй кластер багийг байгуулан үр дүнтэй ажиллаж байна.
- Увс аймгийн чацаргана тариалагчдад зориулж 8 удаагийн сургалт зохион байгуулж 450 хүн хамрагдсан.
- 9 сарын 24-10 сарын 8-ны хооронд ХБНГУ-ын чацарганы салбартай танилцах туршлага судлах ажлыг зохион байгуулсан. Туршлага судлах ажилд Увс аймгаас 7, Улаанбаатар хотоос 3, МҮХАҮТ-аас 3 хүн хамрагдсан.
- Хамтын ажиллагааны төслийн хүрээнд МҮХАҮТ болон ШУТИС-ийн Хүнс Судлалын Төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
- Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6-р багийн төвд малчдад зориулсан сургалт зохион байгуулсан ба нийт 80 малчин хамрагдсан.
- Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6-р багт Хонь хяргах, угаах болон ноос хадгалах загвар төв байгуулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

### Азийн сан, Койка ОУБ, НЗДТГ-тай хамтарсан бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төсөл

МҮХАҮТ-аас Монгол дахь Азийн сангийн суурин төлөөлөгчийн газар, Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага KOICA, НЗДТГ, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төслийг 2016-2018 он хүртэл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2016 онд сургалт, уулзалт, зөвлөх үйлчилгээ гэсэн 3 нэр төрлийн үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:

- **Сургалт:** 6 нэр төрлийн 24 цагийн сургалтанд 180 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- **В2В уулзалт:** “Эрсдэл үү боломж уу” сэдвийн хүрээнд 192 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- **Туршлага судлах аялал:** Батзүү ХХК-ийн үйл ажиллагаатай танилцах туршлага судлах аялалд 45 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- **Зөвлөх үйлчилгээ:** Бизнес инкубатор төвийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу “Бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар, дизайн, сав баглаа боодол” сэдвийн хүрээнд 5 хүнд 2 удаа 10 цагийн зөвлөх үйлчилгээг үзүүлэв. Төслийн хүрээнд нийт давхардсан тоогоор 422 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдав.



### “Entrepreneurship challenges” орон нутагт гарааны бизнесийг дэмжих төсөл

Эдийн засгийн хүндрэл сүүлийн 2 жил үргэлжилж улс орон даяар бизнесийн идэвхи санаачилга буурч байгаа энэ үед орон нутагт бизнес эрхлэх шинэ санаа санаачилгыг өрнүүлэх, тэдэнд хэрхэн бизнесийн санаагаа загварчлах талаар мэдлэг, зөвлөгөө өгөх, тэднийг томоохон чадавхитай компаниудтай холбож өгөх замаар санаагаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, цаашлаад



орон нутагт үнэ цэнэтэй бизнесүүдийг бий болгох зорилгоор “Амаржаргал сан”-тай хамтран “Entrepreneurship challenges” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд “Эдийн засаг, бизнес дэх сорилтууд” сэдэвт сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад зохион байгуулж 400 гаруй бизнес эрхлэгчидийг хамруулсан.




# ТАНХИМЫН ДОТООДОО ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

## Олон улсын худалдааны төвөөс МҮХАҮТ-ын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ

ОУХТ-ийн экспертүүд Мартин Лаббе, Жорж Фишер нар МҮХАҮТ дээр ажилласан.

МҮХАҮТ-ын үйл ажиллагааны харьцуулсан үнэлгээг нийт 225 үзүүлэлтээр манлайлал болон үндсэн чиглэл, үр дүн болон хэмжилт, нөөц болон үйл явц,

бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлт зэрэг 4 үндсэн чиглэлээр үнэлэв. МҮХАҮТ нь ОУХТ-өөс энэхүү үнэлгээг хийж буй 40 дэх худалдааг дэмжих байгууллага болсон бөгөөд үйл ажиллагаа 46.43% оноо авч дэлхийн танхимуудтай харьцуулахад дундаж зэрэглэлд үнэлэгдэв.



© ITC. All Rights Reserved

Уг үнэлгээг хийх хугацаандаа МҮХАҮТ-ын сул болон давуу талыг тодорхойлсон ба үр дүн дээр тулгуурлан Танхимын Гүйцэтгэлийг сайжруулах замын зураглал (PIRM - Performance Improvement Road Map)-ыг гаргахаар дахин ирж ажилласан ба үндсэн 4 зорилгыг тавьж 2017-2018 онд МҮХАҮТ-ыг дэмжиж ажиллахаар болов.



Үүнд:


1. Байгууллагын бүтэцтэй уялдсан тодорхой, хэмжигдэхүйц стратегийн зорилтуудтай болох
2. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй болох
3. Бүрэн боловсруулсан хүний нөөцийн бодлоготой болох
4. Үр дүн, гүйцэтгэлийг системтэйгээр хэмжиж, хяналт шилжилгээ хийдэг болох

## Нидерландын ахмад экспертүүдийн холбооны зөвлөх Фред дэ Боер “Дотоод нөөц бололцоогоо ашиглах нь” төсөл

МҮХАҮТ-ын одоогийн нөхцөл байдлыг үнэлэх, сайжруулалт хийх төлөвлөгөө боловсруулах зорилгоор “Дотоод нөөц бололцоогоо ашиглах нь” Inside Out 1.0 төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд ажилтнуудыг чадавхижуулах багаар ажиллах дасгал сургалтуудыг 5 удаа зохион байгуулж, танхимын ажилтнуудтай уулзаж үнэлт дүгнэлт гаргасан.

Мөн төслийн 2 дах үе шат “Inside Out 2.0” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд МҮХАҮТ дээр Өөрийн удирдлагат

багуудыг бий болгох, Танхимын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх гэсэн 2 зорилтын хүрээнд ажиллаж Борлуулалт, Харилцаа холбоо, Бүтээгдэхүүний багц, Хүний нөөц, Салбар танхимын үйл ажиллагааг дэмжих гэсэн 5 өөрийн удирдлагат баг байгуулсан ба Танхимын бүтэц зохион байгуулалтын шинэ загвар төслийг танхимын гүйцэтгэх удирдлага, ажилтнуудтай хамтарч гарган, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж байна.





## Чанарын удирдлагын ISO9001 стандартын тогтолцоо

МҮХАҮТ өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулах, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, газар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор чанарын удирдлагын ISO9001:2016 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. 2016 онд уг төслийн хүрээнд:

- Удирдлагын хороо, ажлын хэсэг гэсэн 2 багийг бүрдүүлэн ажилласан
- Нийт ажилтнуудыг чадавхижуулах 8 удаагийн сургалт явуулсан.
- Газруудын үйл ажиллагаанд зөрүүний шинжилгээ хийсэн
- Чанарын бодлого, чанарын зорилтуудыг тодорхойлсон.
- Танхимын сонирхогч талуудын эрсдэл ба боломж
- Танхимын давуу болон сул талуудын эрсдэл ба боломж



## Танхимын Брэндбүүк

Танхимын нэр хүнд, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах зорилгоор брэндбүүк гаргасан.

**Энэ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн.**

- Танхимын логог сайжруулах
- Танилцуулга
- Танхимын уриа үг
- Албан бланк
- Хэвлэмэл материалууд
- Танхим болон салбар танхимуудын фэйсбүүк хуудасны шинэчлэл
- Танхимын тор
- Танхимын ажилчдын хувцаслалт
- 2017 оны календарь
- 21 аймагт брэндбүүкт хамруулан нэгдсэн стандартай болгож байна.



МОНГОЛ АЖ ҮЙЛДВЭРМЭН

*Мань бизнесийн  
дуу хоолой*

Монгол Улс, Улаанбаатар 17011,  
Хан-Уул дүүрэг, 15-р хороо,  
Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр.  
Улаанбаатар шуудан -101011001

    /mongolchamber

[www.mongolchamber.mn](http://www.mongolchamber.mn)